



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 30өдөр

Дугаар 617

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 269 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Худалдах, худалдан авах гэрээний маягтад дор дурдсан нэмэлт оруулсугай.

1.1. “Нэг Ерөнхий зүйлийн 1.4. худалдах худалдан авах гэрээ байгуулах албан хаагч ёс зүйн хэм хэмжээг чанд сахин, авлигаас ангид, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ” гэж;

1.2. “1.5. Гэрээ байгуулах явцад гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй гарсан, гарах нөхцөл бүрдсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлийг олж мэдсэн тохиолдолд нэн даруй эрх бүхий байгууллага, этгээдэд мэдэгдэнэ” гэж;

1.3. “1.6. Төрийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулсан дуудлагын худалдааны үр дүнгээр худалдах, худалдан авах гэрээнд оролцогч талуудыг төлөөлж буй этгээд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх тохиолдолд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан мэдэгдлийг гаргаж, өөрийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд бүртгүүлнэ” гэж.

2. Тогтоолыг нийт төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ